

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН 2022 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.07.04

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	
<p align="center">Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерти зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>				
<p>4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</p>	1	<p>Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно.</p>	Жилдээ	<p>Албан тушаалд томилогдох 3 албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж байна.</p>
	2	<p>Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод нээлттэй болгоно.</p>	Жилдээ	<p>Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд 2022.06.20-ны өдрийн 1/852 тоот албан бичгээр хүргүүллээ.</p>

	3	Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.	Жилдээ	Төрийн захиргааны 40 ажлын байрны 23 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2022.05.18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн ТАЗ-ийн 369 дүгээр тогтоолоор зөвшөөрөл авч, газрын даргын 2022.06.24-ний өдрийн А/245 дугаар тушаалаар баталсан.
4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	4	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Жилдээ	Төрийн захиргааны удирдах албан тушаалд 1 албан хаагчийг, гүйцэтгэх албан тушаалд 2 албан хаагчийг дэвшүүлэн томилсон.
4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	5	Засгийн газрын 2020 оны 2018 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангана.	Жилдээ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний аргачлал загварын дагуу үнэлэх, дүгнэх үйл ажиллагааг байгууллагын Үнэлгээний баг хэрэгжүүлж байна.

<p>4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>6</p>	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.</p>	<p>Жилдээ</p>	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл тайлант хугацаанд ирээгүй болно.</p>
<p>Хоёр.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>				
<p>4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх</p>	<p>7</p>	<p>Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар үр дүнг сайжруулна.</p>	<p>Жилдээ</p>	<p>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлэх өргөдөл, гомдлыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ERP системээс гадна, өргөдөл, гомдлыг ажлын байранд бичгээр шууд хүлээн авах, утсаар авах зэргээр хүлээн авч, хариуцсан албан тушаалтан болон Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс шийдвэрлэлтийн чанар, үр дүнг шалган дүн шинжилгээ хийж хэвшлээ.</p>
<p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах чиглэлээр</p>				
	<p>8</p>	<p>Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангана;</p>	<p>Жилдээ</p>	<p>Байгууллагын шилэн дансны мэдээллийн самбарт 2022 оны батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого,</p>

<p>Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн орлого, түүний зарцуулалтыг хуулийн хугацаанд цахим хуудаст тухай бүр мэдээлэх</p>	<p>9</p>	<p>Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлнэ;</p>	<p>Жилдээ</p>	<p>зарлагын мөнгөн гүйлгээг сар бүр, төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг улирал бүр, мөн шилэн данстай холбоотой хуулийг ил тод нээлттэй байршуулан ажиллаж байна.</p> <p>Байгууллагын “umch.ub.gov.mn” албан ёсны цахим хуудас болон “shilendans.gov.mn” цахим хуудаст 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнүүд болон орлогын тооцоог ойлгомжтой байдлаар ил тод нээлттэй байршуулсан.</p>
<p>Байгууллагын цахим хуудасны ашиглалтыг сайжруулах, мэдээлэл түгээх арга хэрэгслийг бүрэн ашиглах, мэдээллийг байнга шинэчлэх</p>	<p>10</p>	<p>Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн болон үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан тухай бүр шинэчлэх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Байгууллагын хэмжээнд нийт 15 мэдээ бэлтгэн байгууллагын “umch.ub.gov.mn” албан ёсны цахим хуудаст байршуулсан ба Нийслэлийн мэдээ, Авлигатай тэмцэх газар, АТГ-Олон нийтийн төв болон Хотын соёлын нийт 780 гаруй мэдээг байршуулж, олон нийтэд түгээсэн ба нийт 81,826 удаагийн хандалтаар иргэд мэдээлэл авсан байна.</p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд 2022 оны НИТХ-ын 12 тогтоол, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй НИТХТ-ийн 6 тогтоолын устсан файлыг дахин сэргээж, Газрын даргын 2022 оны 90 гаруй А тушаал, байгууллагаас гарсан дүрэм журмыг цахим хуудаст ил тод нээлттэй байршуулсан.</p>

Авлигаас ангид төрийн албан хаагч

<p>Ажлын байран дах ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p align="center">11</p>	<p>Үнэлгээний хороо, ажлын хэсэг, сонгон шалгаруулалтад орж байгаа албан хаагчдын “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргуулж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>Захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвших.</p>	<p align="center">Жилдээ</p>	<p>Газрын даргын 4 удаагийн тушаалаар Сонгон шалгаруулалтад оролцсон 18 албан хаагчийн “Ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүссэн тухай тайлбар мэдэгдэл”-ийн хуудсыг бөглүүлэн, АТГ-ын “meduuleg.iaac.mn” цахим хуудсанд мэдээллийг орууллаа.</p>
---	--------------------------	--	------------------------------	--

Нийслэлийн Өмчийг удирдлага, бүртгэл, хяналтын нэгдсэн, ил тод тогтолцоотой хангах чиглэлээр

<p>Нийслэлийн Өмчийн бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p align="center">12</p>	<p>“Төрийн болон орон нутгийн өмч бүртгэл 1,0” програмд Нийслэлийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд тусгагдсан эд ашиглалтын хөрөнгийг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;</p>		<p>Монгол Улсын Засгийн газраас баталсан “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-аас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-тай хамтран боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн программын серверт 2020 оны 6 дугаар сард гэмтэл гарснаас дахин ашиглах боломжгүй болсон. Иймд Нийслэлийн өмчит нийт 818 байгууллагын тайлан балансыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан захиргааны статистикийн болон бүртгэлийн маягтуудын дагуу 2021 оны тайлан балансыг хүлээн авч нэгтгэсэн. 2021 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө 4,967,820.2 сая төгрөг, үүнээс</p>
---	--------------------------	--	--	---

				эргэлтийн бус хөрөнгө 3,424,339.9 сая, эргэлтийн хөрөнгө 1,543,480.2 сая төгрөг байна. Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газар болон Үндэсний Статистикийн газарт 818 байгууллагын өмчийн бүртгэлийн дүн мэдээг ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу тайлагнаж хүргэсэн.
		Нийслэлийн Өмчийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй эд хөрөнгийн талаар иргэд, аж ахуйн нэгжид лавлагаа гаргах;	Жилдээ	Иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн үл хөдлөх хөрөнгийн нийслэлийн өмчид бүртгэлтэй эсэх 7 лавлагааг албан бичгээр олгосон.
Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнг тооцох механизмыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх;	13	НӨҮГ-уудын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, үр ашиг менежментийг сайжруулах;	Жилдээ	НӨҮГ-уудын 2021 оны контракт дүгнэх ажлын хэсэг байгуулагдаж дүгнэлт гаргаад байна. Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийж баталгаажуулан ирүүлсэн бөгөөд илэрсэн зөрчил, зөвлөмжийг тусган Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.
		Нийслэлийн төсөвт байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, шаардлагатай газруудын асуудлыг НЗД-ын зөвлөлийн хуралд танилцуулах;	1 дүгээр улиралд	Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэгт ажиллан тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Зөвлөлийн хурлын тов гараагүй байна.
Нийслэлийн Өмч хувьчлах ажлыг зохион байгуулах;	14	Хувьчлагдах аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжийн судалгааг гарган танилцуулж, шийдвэр гаргуулан, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьчлах ажлыг зохион байгуулах;	Жилдээ	2022 онд хувьчлагдах 158 барилга байгууламжийг үнэлэх тендер зарлагдан “Мөнх оргил трейд” ХХК ялагчаар шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Үнэлгээний тайлан ирээгүй байна.
		Хувьчлагдах аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжийн худалдах доод үнийг тогтоох	Жилдээ	2022 онд хувьчлагдах 158 барилга байгууламжийг “Мөнх оргил трейд” ХХК

		зорилгоор бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийлгэх, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан, нийтэд ил тод хэлбэрээр зохион байгуулах.		гэрээ байгуулан ажиллаж байна. Үнэлгээний тайлан ирүүлсний дараа Нийслэлийн өмч хувьчлах комисст танилцуулж, тогтоол гарган хувьчлах ажлыг зохион байгуулна.
--	--	--	--	--

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР